



ИНД - 77

Иргэний Нисэхийн Дүрэм

**Нислэг үйлдэх агаарын зайд нөлөөлөх
байгууламж, үйл ажиллагаа**

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-77 нь нислэг үйлдэх агаарын зайд аюул учруулж болох барилга байгууламж барих, эсхүл өөрчлөхийг санал болгож байгаа этгээдэд тавих шаардлагыг тогтооно.

ИНД-77 нь мөн нислэг үйлдэх агаарын зайд аюул учруулж болох барилга байгууламж, гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехникийн ашиглалттай холбоотой шаардлагыг тогтооно.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-77-гийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-77, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх**Хүчинтэй огноо**

Анхны боловсруулалт

2003 оны 05 сарын 01

Нэмэлт, өөрчлөлт 1

2010 оны 05 сарын 07

Нэмэлт, өөрчлөлт 2 (Шинэчлэлт)

2018 оны ... сарын ...

Тэмдэглэл: ИНД-77-гийн шинэчлэлтийг монгол, англи хэл дээр, NZ Part 77 А.4-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

77.1.	Зорилго.....	5
77.3.	Тодорхойлолт	5
77.5.	Барилга байгууламж барих, эсхүл өөрчлөх мэдэгдэл	6
77.7.	Барилга байгууламжид хийн урсгал (efflux), гэрэл, эсхүл лазер ашиглах мэдэгдэл	6
77.9.	Зэвсэг ашиглах мэдэгдэл.....	7
77.11.	Пиротехник ашиглах мэдэгдэл	7
77.13.	Мэдэгдлийн шаардлага.....	7
77.15.	Нэмэлт мэдэгдлийн шаардлага	8
77.17.	Нисэхийн судалгаа	8
77.19.	Аюулыг тодорхойлох стандарт	9
77.21.	Шийдвэр гаргах.....	10
77.23.	Дагаж мөрдөх.....	11
77.25.	Шийдвэрийн хүчинтэй өдөр болон хугацаа	11
77.27.	Аюултай гэсэн шийдвэрийг эргэн хянах хүсэлт.....	11
77.29.	Аюулгүй гэсэн шийдвэрийг эргэн хянах, эсхүл сунгах хүсэлт	12
Хавсралт А - Гадаргуугийн Саадын Мэдэгдэл		14
Хавсралт В - Саадыг тэмдэглэх ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ		15
В.1.	Саад	15
В.2.	Тэмдэглэсэн, эсхүл гэрэлтсэн байх саад.....	15
В.3.	Ерөнхий зүйл	16
В.4.	Өнгө ашиглах	16
В.5.	Тэмдэглэгээ ашиглах.....	17
В.6.	Дарцаг ашиглах	18
В.7.	Саадын гэрэл ашиглах.....	18
В.8.	Саадын гэрэлтүүлгийн байрлал	19
В.9.	Бага чадалтай саадын гэрлийн үзүүлэлт.....	21
В.10.	Дунд чадалтай саадын гэрлийн үзүүлэлт	22
В.11.	Өндөр чадалтай саадын гэрлийн үзүүлэлт	22
Хавсралт С - Халхлалт		22

77.1. Зорилго

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, энэ Дүрэм нь Монгол Улсын зэвсэгт хүчний харъяалах бүсийг оролцуулан, Монгол Улсын нутаг дэвсгэрт дараах үйл ажиллагаа хийхийг санал болгож байгаа этгээдэд тавих шаардлагыг тогтооно:

- (1) нислэг үйлдэх агаарын зайд аюул үүсгэж болох барилга байгууламж барих, эсхүл өөрчлөх; эсхүл
- (2) нислэг үйлдэх агаарын зайд аюул үүсгэж болох барилга байгууламж, гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглах.

(b) Энэ Дүрэм нь дараах зүйлд хамаарахгүй:

- (1) Монгол Улсын зэвсэгт хүчний аливаа анги салбар, эсхүл дараах үйл ажиллагаатай холбоотой үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын зэвсэгт хүчний аливаа агаарын хөлөг:
 - (i) дайны, эсхүл бусад онцгой нөхцөл; эсхүл
 - (ii) Монгол Улс болон Монгол Улсын бусад ашиг сонирхол; эсхүл
 - (iii) онцгой нөхцөлийн үед ард иргэдэд тусламж үзүүлэх; эсхүл
 - (iv) нийтэд чиглэсэн аливаа үйлчилгээ үзүүлэх; эсхүл
 - (v) ИНД-71-ийн дагуу цэргийн зорилгоор тогтоосон хязгаарлалттай, аюултай, эсхүл цэргийн үйл ажиллагааны бүсэд гүйцэтгэсэн аливаа ажиллагаа;
- (2) ИНД-101-д хамаарах үйл ажиллагаа.

77.3. Тодорхойлолт

Энэ Дүрэмд:

ICAO Doc 8168-OPS/611 гэж ОУИНБ-ын Консулын шийдвэрээр баталж, хэвлэн тараасан агаарын навигацийн үйлчилгээ болон агаарын хөлгийн үйл ажиллагааны журмыг;

Нислэг үйлдэх агаарын зай гэж Монгол Улсын зэвсэгт хүчний үйл ажиллагаанд ашиглахаар зориулан тогтоосон хязгаарлалттай, аюултай болон цэргийн үйл ажиллагааны бүсээс бусад, нам түвшний нислэгийн үйл ажиллагааг багтаасан, ИНД-ийн дагуу тогтоосон, эсхүл түүнд заасан тухайн минимум нислэгийн түвшинд, эсхүл түүнээс дээш орших агаарын зайг;

Саадын хязгаарлалтын гадаргуу гэж тухайн аэродромын үйл ажиллагааг аюулгүй явуулах, аэродромын эргэн тойрны саадын өсөлтийн улмаас тухайн аэродромыг ашиглах боломжгүй болохоос сэргийлэх зорилгоор аэродромын эргэн тойронд тусгайлан тогтоосон агаарын зайг;

Тухайн байрлалын газрын түвшин гэж тухайн байрлалын эргэн тойрон 600м радиус доторх хамгийн өндөр газрыг.

77.5. Барилга байгууламж барих, эсхүл өөрчлөх мэдэгдэл

Барилга байгууламж барих, эсхүл өөрчлөхийг санал болгож байгаа этгээд нь 77.13-ын дагуу тухайн саналыг Даргад мэдээлэх үүрэгтэй, хэрэв санал болгосон барилга байгууламж, эсхүл өөрчлөлт нь:

- (1) тухайн байрлалын газрын түвшнээс дээш 60м-ээс өндөр байх бол; эсхүл
- (2) тухайн бүсийн модны нийтлэг өндрөөс 18м-ээр дээш болон нам түвшний агаараас гүйцэтгэх ажиллагааны, эсхүл бусад нам түвшний нислэгийн бүс, эсхүл ИНД-71-ийн дагуу тогтоосон нам өндрийн нислэгийн зоон, эсхүл нам түвшний нислэгийн замд байрлаж байгаа бол; эсхүл
- (3) Хавсралт А-ийн А.1 болон А.2 зурагт дүрсэлсэн аэродромын ойртолтын, эсхүл хөөрөлтийн гадаргуугаас доош байрлаж байгаа, Хавсралт А-д харуулсан гадаргуугаас өндөр, дараах аль нэг нөхцөлөөс дээш болон илүү гарсан бол:
 - (i) МСТОВ нь 5700кг-аас дээш агаарын хөлөг ашигладаг, эсхүл ашиглахаар төлөвлөж байгаа бол, налуу нь ХБЗ-ын хөөрөлтийн гадаргуугийн эхлэл цэгээс 1:83;
 - (ii) МСТОВ нь 5700кг, эсхүл түүнээс доош агаарын хөлөг ашигладаг, эсхүл ашиглахаар төлөвлөж байгаа бол, налуу нь ХБЗ-ын хөөрөлтийн гадаргуугийн эхлэл цэгээс 1:50;
 - (iii) налуу нь нисдэг тэрэгний аюулгүй байдлын бүсийн хамгийн ойрын цэгээс 1:25; эсхүл
- (4) аэродромын конус, дотор талын хэвтээ, эсхүл шилжилтийн хажуу гадаргууг дараах байдлаар огтолсон бол:
 - (i) Хавсралт А-ийн А.1-д дүрсэлсэн; эсхүл
 - (ii) ИНД-139-д заасан; эсхүл
 - (iii) тухайн орон нутгийн схемд тодорхойлсон.

77.7. Барилга байгууламжид хийн урсгал (efflux), гэрэл, эсхүл лазер ашиглах мэдэгдэл

(a) Барилга байгууламж ашиглахаар санал болгож байгаа этгээд нь 77.13-ын дагуу тухайн саналыг Даргад мэдээлэх үүрэгтэй, хэрэв:

- (1) тухайн барилга байгууламж нь аэродромын саадыг хязгаарлах бүсийг огтлон 4.3м/с-ээс дээш хурдтай хийн урсгал (нөөлөг) үүсгэх бол; эсхүл
- (2) тухайн барилга байгууламж нь газрын түвшнээс 60м-ээс дээш өндөрт 4.3м/с-ээс дээш хурдтай хийн урсгал (нөөлөг) үүсгэх бол.

(b) Гэрэл, эсхүл лазер ашиглахаар санал болгож байгаа этгээд нь 77.13-ын дагуу Даргад мэдээлэх үүрэгтэй, хэрэв:

- (1) гэрэл, эсхүл лазер нь нисгэгчийн харааг гялбуулах, эсхүл бусдаар нөлөөлснөөр агаарын хөлөгт аюул учруулах бол; эсхүл

- (2) лазерын хувьд, тусгал нь нислэг үйлдэх агаарын зайд хэрэглэгдэх S/AS 2211 стандартад заасан зөвшөөрөгдөх максимум хэмжээнээс их бол; эсхүл
- (3) дараах төхөөрөмжид гарсан алдаанаас агаарын хөлөгт аюул учруулах бол:
 - (i) аэродромд, эсхүл түүний ойролцоо байрлуулсан, эсхүл байрлуулахыг зөвшөөрсөн гэрэл, эсхүл гэрэлтүүлгийн системийн хэсэг; эсхүл
 - (ii) нислэг үйлдэх агаарын зайн аюулын гэрлэн тэмдэглэгээ.

77.9. Зэвсэг ашиглах мэдэгдэл

Хэрэв тухайн этгээд, эсхүл байгууллагыг төлөөлсөн этгээд нь дараах өндрөөс дээш нисэх траектортой пуужин/сум хөөргөх, эсхүл буудах зэвсэг ашиглахаар санал болгож байгаа бол, 77.13-ын дагуу Даргад мэдээлэх үүрэгтэй:

- (1) хэрэв аэродромын хил хязгаараас 4км-ийн дотор бол, 45м-ээс; эсхүл
- (2) хэрэв аэродромын хил хязгаараас 4км-ээс хол зайтай бол, 120м-ээс.

77.11. Пиротехник ашиглах мэдэгдэл

(a) Хэрэв этгээд нь дараах өндрөөс дээш нисэх траектортой пуужин/сум хөөргөх, эсхүл буудах ажиллагаа оролцсон пиротехникийн үзүүлбэр хийхээр санал болгож байгаа бол, 77.13-ын дагуу Даргад мэдээлэх үүрэгтэй:

- (1) хэрэв аэродромын хил хязгаараас 4км-ийн дотор бол, 45м-ээс; эсхүл
- (2) хэрэв аэродромын хил хязгаараас 4км-ээс хол зайтай бол, 120м-ээс.

77.13. Мэдэгдлийн шаардлага

(a) Энэ зүйлийн (b) болон (c)-г харгалзан, 77.5, 77.7, 77.9, эсхүл 77.11-ийн дагуу Даргад мэдээлэх шаардлагатай этгээд нь САА 24077/01 маягтыг бөглөж, дараах хугацаанд Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) 77.5-ын дагуу барилга байгууламж барих, эсхүл өөрчлөхөөр санал болгосон өдрөөс 90 хоногийн өмнө; эсхүл
- (2) 77.7, 77.9, эсхүл 77.11-ийн дагуу ашиглахаар санал болгосон өдрөөс ажлын 5 хоногийн өмнө.

(b) Барилга байгууламжийг яаралтай барих, эсхүл өөрчлөх, эсхүл барилга байгууламж, гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглахыг шаардсан, нийтийн зайлшгүй үйлчилгээ, нийтийн эрүүл мэнд, эсхүл нийтийн аюулгүй байдалтай холбоотой онцгой нөхцөл бий болсон тохиолдолд:

- (1) энэ зүйлийн (a)-д заасан мэдэгдлийн шаардлага хамаарахгүй;
- (2) тухайн барилга байгууламжийг барих, өөрчлөх, эсхүл ашиглахыг хариуцсан этгээд нь тухайн барилга байгууламжийг барьж, өөрчилж, эсхүл ашигласнаас хойш ажлын 5 хоногийн дотор САА 24077/01 маягтыг бөглөж, Даргад хүргүүлэх үүрэгтэй.

(с) Холбогдох НХУ-ний нэгж хяналт тавьж байгаа үед, ИНД-71-ийн дагуу тогтоосон хяналттай зоонд гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглахаар санал болгож байгаа этгээдийг:

- (1) энэ зүйлийн (а)-ийн дагуу мэдэгдэл хүргүүлэхийг шаардахгүй;
- (2) тухайн агаарын зайг хариуцсан НХУ-ын нэгжээс ашиглалт эхлэхээс өмнө ажлын 5 хоногт өгсөн байх ёстой урьдчилсан зөвшөөрөлгүйгээр, хяналттай зоонд гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглахыг хориглоно.

77.15. Нэмэлт мэдэгдлийн шаардлага

(а) Энэ дүрмийн 77.5 болон 77.7-гийн дагуу Даргад мэдээлэх шаардлагатай этгээд нь, хэрэв Дарга шаардвал, барилга байгууламж барих, өөрчлөх, эсхүл ашиглаж эхлэх (аль хамааралтайг) тухайн огноог Даргад бичгээр мэдээлэх үүрэгтэй.

(б) Барилга байгууламж барих, эсхүл өөрчлөх талаар 77.5-ын дагуу Даргад мэдээлэх шаардлагатай этгээд нь, тухайн барилга байгууламж өөрийн хамгийн дээд өндөрт хүрсэн үед ажлын 5 хоногийн дотор Даргад бичгээр мэдээлэх үүрэгтэй.

(с) Тухайн барилга байгууламж өөрийн хамгийн дээд өндөрт хүрсэн үед, энэ зүйлийн (б)-д шаардсан мэдэгдэл нь, бүртгэлтэй геодезийн ажилтны гаргасан, тухайн барилга байгууламжийн өндөр болон байршлын тодорхойлолт болон 77.21(d)-гийн дагуу Даргын тогтоосон аливаа тэмдэглэгээ, гэрэлтүүлгийн шаардлагын нийцлийн баталгааг агуулсан байх ёстой.

(д) Энэ дүрмийн 77.5-ын дагуу мэдэгдэл гаргах байгууламжийг барих, эсхүл өөрчлөх төслийг зогсоосон этгээд нь тухайн төслийг зогсоосноос хойш ажлын 5 хоногийн дотор Даргад бичгээр мэдээлэх үүрэгтэй.

(е) Барилга байгууламжийг буулгаж байгаа, эсхүл нураасан барилга байгууламжид хариуцлага хүлээсэн этгээд нь, хэрэв тухайн барилга байгууламж нь 77.5-ын дагуу мэдэгдлийн шалгуурыг хангасан бол, тухайн барилга байгууламжийг буулгасан, эсхүл нурааснаас хойш ажлын 5 хоногийн дотор Даргад бичгээр мэдээлэх үүрэгтэй.

77.17. Нисэхийн судалгаа

(а) Дарга, энэ дүрмийн 77.5, 77.7, 77.9, эсхүл 77.11-ийн дагуу мэдэгдэл хүлээн авч, хэрэв тухайн саналыг хэрэгжүүлсэн тохиолдолд, нислэг үйлдэх агаарын зайд аюул учруулах эсэхийг тодорхойлох зорилгоор нисэхийн судалгаа хийнэ.

(б) Дарга тухайн нисэхийн судалгааг хийхдээ, өөрийн хамааралтай гэж үзсэн этгээд, үйлдвэрлэлийн төлөөлөл, төлөөллийн бүлэг болон байгууллагатай зөвлөлдөнө.

77.19. Аюулыг тодорхойлох стандарт

(a) Хэрэв барилга байгууламж нь тухайн байрлалын газрын түвшнээс дээш 120м, эсхүл түүнээс өндөр бол, Дарга тухайн барилга байгууламж нислэг үйлдэх агаарын зайд аюул учруулж болохыг тодорхойлох үүрэгтэй.

(b) Хэрэв барилга байгууламж нь тухайн аэродромд хамааралтай саадыг хязгаарлах гадаргууг дайрч 4.3м/с-ээс дээш хурдтай хийн урсгал үүсгэх, эсхүл үүсгэж болох бол, Дарга тухайн барилга байгууламжийг ашиглах нь нислэг үйлдэх агаарын зайд аюул учруулж болохыг тодорхойлох үүрэгтэй.

(c) Хэрэв барилга байгууламж нь газрын түвшнээс дээш 120м-ээс өндөр, 4.3м/с-ээс дээш хурдтай хийн урсгал үүсгэх, эсхүл үүсгэж болох бол, Дарга тухайн барилга байгууламжийн ашиглалт нь нислэг үйлдэх агаарын зайд аюул учруулж болохыг тодорхойлох үүрэгтэй.

(d) Хэрэв тухайн гэрлийн хэрэглээ нь нислэг үйлдэх агаарын зайд аюул үүсгэхийг шинжилгээгээр илрүүлсэн бол, Дарга тухайн гэрлийн хэрэглээ нислэг үйлдэх агаарын зайд аюул учруулж болохыг тодорхойлох үүрэгтэй.

(e) Хэрэв лазерын тусгал нь нислэг үйлдэх агаарын зайд хэрэглэгдэх S/AS 2211 стандартад заасан зөвшөөрөгдөх максимум хэмжээнээс их бол, Дарга санал бүрийн тодорхой нөхцөлд үндэслэн тухайн лазерын хэрэглээ нислэг үйлдэх агаарын зайд аюул учруулж болохыг тодорхойлж болно.

(f) Хэрэв тухайн зэвсгийн хэрэглээ нь нислэг үйлдэх агаарын зайд аюул үүсгэхийг шинжилгээгээр илрүүлсэн бол, Дарга тухайн зэвсгийн хэрэглээ нислэг үйлдэх агаарын зайд аюул учруулж болохыг тодорхойлох үүрэгтэй.

(g) Хэрэв тухайн пиротехникийн хэрэглээ нь нислэг үйлдэх агаарын зайд аюул үүсгэхийг шинжилгээгээр илрүүлсэн бол, Дарга тухайн пиротехникийн хэрэглээ нислэг үйлдэх агаарын зайд аюул учруулж болохыг тогтоох үүрэгтэй.

(h) Дарга санал бүрийн тодорхой нөхцөлд үндэслэн, тухайн барилга байгууламж нь нислэг үйлдэх агаарын зайд аюул учруулж болохыг тодорхойлж болно, хэрэв:

(1) энэ нь ICAO Doc 8168-OPS/611-т заасан хэрэглэлийн нислэгийн журмын бүсэд байрладаг, стандарт нисэн ирэх зам, эхэн, дунд, төгсгөлийн, ил харааны болон хоёрдугаар тойрогт гарах үе шатны бүс, нисэн гарах бүс болон стандарт хэрэглэлээр гарах замыг багтаасан бөгөөд дараах нөлөө үзүүлэх бол:

(i) тухайн бүс, эсхүл сегментийн доторх барилга байгууламжийн аливаа цэг болон тогтоосон минимум хэрэглэлийн нислэгийн түвшний хоорондын босоо зай нь хэрэглэлийн нислэгийн журмаар шаардсан саадыг давах өндрөөс бага болох; эсхүл

(ii) тухайн бүсээс нисэн гарахад хамаарах нэмэлт, эсхүл шинэ үүлний суурийн өндөр, эсхүл алсын барааны харагдацын хязгаарлалт, эсхүл нислэгийн журмын өөрчлөлтөд; эсхүл

- (2) энэ нь хэрэглэлийн нислэгийн журмаар нислэг үйлдэх агаарын замын саадыг давах бүсэд байрладаг, Монгол Улсын агаарын замын сүлжээ болон бүсийн зургийг багтаасан, гэхдээ Монгол Улсын AIP-д хэвлэгдсэн, зурагдсан замыг оруулаагүй бөгөөд мөрдөгдөж байгаа, эсхүл төлөвлөсөн минимум саадыг давах түвшинг нэмэгдүүлэхийг шаардсан бол; эсхүл
- (3) тухайн бүсийн модны нийтлэг өндрөөс 18м-ээр илүү гарсан, нам түвшний агаараас гүйцэтгэх ажиллагааны, эсхүл бусад нам өндрийн нислэгийн бүс, эсхүл ИНД-71-ийн дагуу тогтоосон нам өндрийн нислэгийн зоон, эсхүл нам түвшний нислэгийн замд байрласан бол; эсхүл
- (4) энэ нь тухайн аэродромын саадыг хязгаарлах гадаргууг нэвтлэх бол.

77.21. Шийдвэр гаргах

(a) Дарга, 77.13(a)-ийн дагуу барилга байгууламж барих, өөрчлөх, эсхүл ашиглах аливаа мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 28 хоногийн дотор, хэрэв тухайн саналыг хэрэгжүүлсэн бол, санал болгосон барилга байгууламжийг барих, өөрчлөх, эсхүл ашиглах нь нислэг үйлдэх агаарын зайд аюултай эсэхийг тодорхойлох шийдвэр гаргаж, мэдэгдэл гаргагч болон тухайн шийдвэрт хамаатай гэж үзсэн аливаа бусад этгээдэд мэдэгдэнэ.

(b) Дарга, 77.13(a)-ийн дагуу гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглах аливаа мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор, хэрэв тухайн саналыг хэрэгжүүлсэн бол, санал нь нислэг үйлдэх агаарын зайд аюултай эсэхийг тодорхойлох шийдвэр гаргаж, мэдэгдэл гаргагч болон тухайн шийдвэрт хамаатай гэж Даргын үзсэн аливаа бусад этгээдэд мэдэгдэнэ.

(c) Дарга, 77.13(c)-гийн дагуу аливаа мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 4 хоногийн дотор, хэрэв тухайн саналыг хэрэгжүүлсэн бол, санал болгосон гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглах нь, нислэг үйлдэх агаарын зайд аюултай эсэхийг тодорхойлох шийдвэр гаргаж, мэдэгдэл гаргагч болон тухайн шийдвэрт хамаатай гэж Даргын үзсэн аливаа бусад этгээдэд мэдэгдэнэ.

(d) Дарга, шийдвэр бүрийг нисэхийн судалгаагаар илрүүлсэн дутагдалд үндэслэн гаргах бөгөөд:

- (1) дараах аливаа нөхцөл, эсхүл хязгаарлалтыг тогтоож болно:
 - (i) Хавсралт В -д үзүүлсэн тэмдэглэгээ, эсхүл гэрэлтүүлгийн бүтцэд;
 - (ii) нислэг үйлдэх агаарын зайд учрах аюулыг хамгийн бага түвшинд хүргэхийг бататгах;
 - (iii) нислэг үйлдэх агаарын зайд аюулгүй гэсэн шийдвэрт, боломжит асуудлыг багасгахад шаардлагатай гэж үзсэн, жишээ нь: барилга байгууламжийн түр зуурын төхөөрөмж ашиглах;
- (2) мэдэгдэлд тавих нэмэлт шаардлагыг тодорхойлж болно.

77.23. Дагаж мөрдөх

Даргад мэдэгдэл хүргүүлэх 77.5, 77.7, 77.9, эсхүл 77.11-т шаардсан этгээд бүр нь 77.21(d)-гийн дагуу тогтоосон аливаа шаардлага, нөхцөл, эсхүл хязгаарлалтыг дагаж мөрдөнө.

77.25. Шийдвэрийн хүчинтэй өдөр болон хугацаа

(a) Дараах санал болгосон ажлын талаарх шийдвэр нь:

- (1) Дарга 77.27(b)-гийн дагуу эргэн хянах хүсэлт хүлээн авснаас бусад тохиолдолд, 77.13(a)-ийн дагуу мэдэгдсэн барилга байгууламж барих, өөрчлөх, эсхүл ашиглах үйл ажиллагаа нь 77.21(a)-ийн дагуу тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш 28 хоногийн дараа эцсийн байдлаар хүчинтэй болно;
- (2) Дарга 77.27(b)-гийн дагуу эргэн хянах хүсэлт хүлээн авснаас бусад тохиолдолд, 77.13(a)-ийн дагуу мэдэгдсэн гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглах ажиллагаа нь, САА 24077/01 маягтаар Даргад хүргүүлсэн, ашиглахаар санал болгосон өдрөөс ажлын 5 хоногийн өмнө эцсийн байдлаар хүчинтэй болно.

(b) 77.29-ийн дагуу эргэн хянасан, эсхүл сунгаснаас бусад тохиолдолд, нислэг үйлдэх агаарын зайд аюулгүй болох талаар энэ Дүрмийн дагуу гаргасан эцсийн шийдвэр нь:

- (1) барилга байгууламж барих, өөрчлөх, эсхүл ашиглах үйл ажиллагааны хувьд, тухайн шийдвэр эцсийн байдлаар хүчинтэй болсноос хойш 18 сарын дараа, эсхүл санал болгосон барилга байгууламж барих, өөрчлөх, эсхүл ашиглах ажиллагааг цуцалсан өдрийн аль түрүүлж болох хугацаанд хүчингүй болно;
- (2) гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглах талаар САА 24077/01 маягтаар Даргад мэдэгдсэн ажиллагааг гүйцэтгэж дуусахад, эсхүл санал болгосон ажиллагааг цуцалсан өдрийн, аль түрүүлж болох хугацаанд хүчингүй болно.

(c) Аюултай гэж гарсан эцсийн шийдвэр нь :

- (1) 77.25(a)(1), эсхүл 77.27(f)(2)-ын дагуу, барилга байгууламж барих, өөрчлөх, эсхүл ашиглах ажиллагаатай холбоотой гарсан бол, хүчингүй болохгүй, гэхдээ Дарга бичгээр хүчингүй болгож болно;
- (2) 77.25(a)(2), эсхүл 77.27(f)(2)-ын дагуу, гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглах ажиллагаатай холбоотой бол, САА 24077/01 маягтад тусгасан ажиллагааг гүйцэтгэж дуусахад, эсхүл Дарга сунгахыг зөвшөөрсөн өдрийн дараах өдөр хүчингүй болно.

77.27. Аюултай гэсэн шийдвэрийг эргэн хянах хүсэлт

(a) Барилга байгууламж барих, эсхүл өөрчлөх, эсхүл барилга байгууламж, гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглахаар санал болгож байгаа этгээд нь Даргын гаргасан аюултай гэсэн шийдвэрийг эргэн хянаж үзэх хүсэлтийг Даргад гаргаж болно.

(b) Аюултай гэсэн шийдвэрийг эргэн хянаж үзэх тухай бичгээр гаргасан хүсэлт нь 77.25(a)-ийн дагуу шийдвэр эцсийн болохоос өмнө Даргад хүргэгдсэн байх ба:

- (1) тухайн хүсэлт нь нисэхийн үндэслэлийн дэлгэрэнгүй мэдэгдлийг багтаасан байх;
- (2) Дарга гаргасан шийдвэр, өөрчлөлт, эсхүл сунгалтаа эргэн хянаж үзэх болсон бодит үндэслэлийг багтаасан ба нисэхийн судалгааны явцад өмнө нь авч үзээгүй, эсхүл хэлэлцээгүй шинэ мэдээлэл, эсхүл баримтыг танилцуулсан байх;
- (3) хэрэв эргэн хянах хүсэлт нь төсөөллийн, журмын тайлбарын, аюулын стандартыг хэрэглэсэн байдлын, эсхүл бодит байдлын таамаглалын алдаанд үндэслэсэн бол, тухайн хүсэлтийн үндэслэлийг тодорхойлж, тайлбарлах.

(c) Энэ зүйлийн (b)-гийн дагуу ирүүлсэн аливаа эргэн хянах хүсэлтийг Дарга шалгаж шийдвэрлэх хүртэл, шийдвэр эцсийн болохгүй.

(d) Энэ зүйлийн (b)-гийн дагуу ирүүлсэн хүсэлт бүрийг Дарга шалгаж үзээд, эргэн хянах эсэхийг шийдвэрлэнэ.

(e) Хэрэв Дарга эргэн хянахыг зөвшөөрсөн бол:

- (1) судалгаа хийх болон эргэн хянах асуудлыг тухайн хүсэлт гаргагчид мэдэгдэнэ, хэрэв тухайн хүсэлтэд харуулсан асуудал, эсхүл шийдвэр зөрүүтэй бол;
- (2) 77.21(a), (b), эсхүл (c)-гийн аль хамааралтай заалтын дагуу шийдвэр гаргахдаа зарцуулсан хугацаанаас бага хугацаанд эргэн хянах ажиллагааг дуусгана.

(f) Хэрэв Дарга тухайн эргэн хянах ажиллагааг татгалзахаар шийдвэрлэсэн бол:

- (1) тухайн шийдвэрийн талаарх үндэслэлийг хүсэлт гаргагчид мэдэгдэнэ;
- (2) эргэн хянах ажиллагааг татгалзсан, эсхүл 77.25(a)-д заасны дагуу аль сүүлд болох хугацаанд тухайн шийдвэр нь эцсийн болно.

77.29. Аюулгүй гэсэн шийдвэрийг эргэн хянах, эсхүл сунгах хүсэлт

(a) Дарга энэ Дүрмийн дагуу нислэг үйлдэх агаарын зайд аюулгүй гэсэн шийдвэр гаргасан тохиолдолд, аливаа этгээд тухайн шийдвэр, түүний хүчинтэй хугацааг сунгахад үндэслэсэн шинэ нөхцөл байдал өөрчлөгдсөнд үндэслэн тухайн шийдвэрийг эргэн хянах хүсэлтийг Даргад гаргаж болно, хэрэв:


- (1) хамааралтай бол, тухайн санал болгосон барилга байгууламжийг барих, эсхүл өөрчлөх, суурь тавих зэрэг барилга угсралтын бодит ажил хийгдэж эхлээгүй бол, гэхдээ малталт орохгүй;
- (2) тухайн хүсэлтийг нислэг үйлдэх агаарын зайд аюулгүй гэсэн эцсийн шийдвэрийн хүчинтэй хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлсэн бол.

(b) Нислэг үйлдэх агаарын зайд аюулгүй гэсэн шийдвэр гаргасан Дарга нь танилцуулсан хүсэлт бүрийг шалгаж, тухайн шийдвэрийг эргэн хянана, эсхүл тухайн шийдвэрийн эхний дуусах хугацааг сунгана, эсхүл батална.


(c) Нислэг үйлдэх агаарын зайд аюулгүй гэсэн шийдвэрийн дуусгавар болох хугацааг:

- (1) 77.25(b)(1)-ийн дагуу, Дарга нэг удаад 6 сараас ихгүй хугацаагаар сунгаж болно;
- (2) 77.25(b)(2)-ын дагуу, Дарга нэг удаад 14 хоногоос ихгүй хугацаагаар сунгаж болно.

Хавсралт А - Гадаргуугийн Саадын Мэдэгдэл



Зураг А.1 - Аэродромын мэдэгдлийн шаардлага



Зураг А.2 - Хелипортын мэдэгдлийн шаардлага

Хавсралт В - Саадыг тэмдэглэх ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ

В.1. Саад

Энэ Хавсралтад, саад гэсэн нэр томъёог 77.21-ийн дагуу аюултай гэж Дарга тодорхойлсон байгууламжид хамааруулан хэрэглэнэ.

В.2. Тэмдэглэсэн, эсхүл гэрэлтсэн байх саад

(а) Дараахаас бусад тохиолдолд, ИНД-139-д шаардсан саадын хязгаарлагдах гадаргуугаас дээш өргөгдсөн суурин саадыг тэмдэглэсэн байх ба, хэрэв тухайн аэродромыг шөнийн цагаар ашигладаг бол, гэрэлтүүлсэн байна:

- (1) тухайн саад нь өдрийн цагаар өндөр чадалтай гэрлээр гэрэлтдэг бол, тухайн тэмдэглэгээг хийхгүй байж болно;
- (2) тухайн саад нь гэрэлт цамхаг бөгөөд нисэхийн судалгаагаар гэрэлт цамхгийн гэрэл хангалттай болохыг харуулсан бол, тухайн гэрэлтүүлгийг хийхгүй байж болно;
- (3) тухайн тэмдэглэгээ, эсхүл гэрэлтүүлгийг дараах тохиолдолд, хийхгүй байж болно:
 - (i) тухайн саад нь тэмдэглэгээтэй, эсхүл гэрэлтүүлэгтэй бусад суурин саадаар халхлагдсан бол; эсхүл
 - (ii) хөдөлгөөнгүй байгууламж, эсхүл уулаар халхлагдсан өргөн хүрээтэй тойргийн хувьд, тухайн тогтоосон нислэгийн замаас доош саадыг давах аюулгүй босоо өндрийг бататгах журмыг тогтоосон бол; эсхүл
 - (iii) нисэхийн судалгаагаар, тухайн саад нь үйл ажиллагаанд ноцтой нөлөө үзүүлэхгүй болохыг тогтоосон бол.

(b) Энэ дүрмийн 77.19-ийн дагуу аюулыг тодорхойлох аливаа стандартыг хангасан, эсхүл түүнээс хэтэрсэн, энэ зүйлийн (а)-д багтаагүй суурин саадыг дараахаас бусад тохиолдолд, тэмдэглэх, эсхүл гэрэлтүүлнэ:

- (1) тухайн саад нь өдрийн цагаар өндөр чадалтай гэрлээр гэрэлтдэг бол, тухайн тэмдэглэгээг хийхгүй байж болно;
- (2) тухайн саад нь гэрэлт цамхаг бөгөөд нисэхийн судалгаагаар гэрэлт цамхгийн гэрэл хангалттай болохыг харуулсан бол, тухайн гэрэлтүүлгийг хийхгүй байж болно;
- (3) дараах тохиолдолд, тухайн тэмдэглэгээ, эсхүл гэрэлтүүлгийг хийхгүй байж болно:
 - (i) тухайн саадыг өөр бусад тэмдэглэгээтэй, эсхүл гэрэлтүүлэгтэй суурин саад халхалж байгаа бол, эсхүл
 - (ii) нисэхийн судалгаагаар тухайн саад нь үйл ажиллагаанд ноцтой нөлөө үзүүлэхгүй болохыг тогтоосон бол.

В.3. Ерөнхий зүйл


Тэмдэглэгээтэй байх шаардлагатай бүх суурин саадыг өнгөөр ялгах ба, гэхдээ энэ нь боломжгүй бол, тухайн саадын хэлбэр, хэмжээ, өнгө нь бусад хэлбэрээр тэмдэглэх шаардлагагүй, хангалттай тод харагдахуйц байхаас бусад тохиолдолд, тэмдэглэгээ, эсхүл дарцгийг тэдгээрт, эсхүл дээр нь байрлуулна.

В.4. Өнгө ашиглах

(а) Тухайн саад, хэрэв түүний босоо хавтгайд буух тусгал нь 1500мм-ээс бага хоёр хэмжээтэй бол, орчны суурь өнгөнд уусахаас бусад тохиолдолд, тод харагдахуйц ганц улбар шар, эсхүл улаан өнгөний аль нэгээр тэмдэглэнэ.

(б) Хэрэв тухайн саад нь үргэлжилсэн гадаргуутай ба түүний босоо хавтгайд буух тусгал нь 4500мм, эсхүл үүнээс дээш хоёр хэмжээтэй бол, дараах байдлаар тэмдэглэнэ:

- (1) тухайн орчны суурь өнгөнд уусахаас бусад тохиолдолд, улбар шар ба цагаан, эсхүл улаан болон цагаан өнгөөр хослуулан;
- (2) Зураг В.1.-т үзүүлсэн тэгш өнцөгт хэлбэрийн хээгээр, талууд нь 1500мм-ээс багагүй, 3000мм-ээс ихгүй байх бөгөөд ирмэгийг нь хүнд өнгөөр эмжсэн байна.



Зураг В.1 - Тэмдэглэгээний үндсэн загварууд

(с) Дараах тохиолдолд, саадыг эрс тэс өнгийн судлаар тэмдэглэнэ:

- (1) хэрэв саад нь үргэлжилсэн гадаргуутай бөгөөд хэвтээ ба босоо хэмжээсийн аль нэг нь 1500мм-ээс их, нөгөө хэмжээс нь 4500мм-ээс бага бол; эсхүл
- (2) хэрэв үзүүлсэн саад нь сараалжин хэлбэртэй бөгөөд босоо, эсхүл хэвтээ хэмжээсийн аль нэг нь 1500мм-ээс их бол. Зураг В.1-ийг үз.

(d) Энэ зүйлийн (с)-д заасан өнгөний судал нь:

- (1) хамгийн урт хэмжээтэй перпендикуляр байрлалтай байна;
 - (2) хамгийн урт хэмжээсийн ойролцоогоор 1/7-тэй, эсхүл 30м-ийн аль багатай тэнцүү өргөнтэй байна;
 - (3) тухайн суурь өнгөнөөс тод харагдахгүй байхаас бусад тохиолдолд, улбар шар болон цагаан өнгөөр хослуулан тэмдэглэнэ;
 - (4) саадын төгсгөлийн ирмэг судлыг хүнд өнгөөр хүрээлнэ.
- (е) Хүснэгт В.1.-т үзүүлсэн судлыг сондгой тоотой байлгах, хамгийн захын төгсгөлийн ирмэг нь хүнд өнгөтэй судалтай байхаар тодорхойлох хялбар томъёололтой байна. Зураг В.1.-г харж болно.

Хүснэгт В.1 - Судлын өргөн

Хамгийн урт хэмжээс		Судлын өргөн
Дурдсанаас багагүй	Дурдсанаас ихгүй	
1.5m	210m	хамгийн урт хэмжээсний 1/7
210m	270m	хамгийн урт хэмжээсний 1/9
270m	330m	хамгийн урт хэмжээсний 1/11
330m	390m	хамгийн урт хэмжээсний 1/13
390m	450m	хамгийн урт хэмжээсний 1/15
450m	510m	хамгийн урт хэмжээсний 1/17
510m	570m	хамгийн урт хэмжээсний 1/19
570m	630m	хамгийн урт хэмжээсний 1/21

В.5. Тэмдэглэгээ ашиглах

Саадын дээр, эсхүл түүний дэргэд байрлуулсан тэмдэглэгээг:

- (1) тухайн саадын ерөнхий байдлыг ил харагдахуйц байршилд байрлуулна;
- (2) тэнгэр цэлмэг байхад, агаарын хөлөг тухайн байгууламжид ойртолт үйлдэж болох бүх талаасаа, дараах зайнаас танигдахуйц байна:
 - (i) агаараас харагдах саадын хувьд, 1000м-ээс доошгүй;
 - (ii) газраас харагдах саадын хувьд, 300м-ээс доошгүй;
- (3) өвөрмөц хэлбэртэй байх ба энэ нь өөр бусад мэдээлэл дамжуулахад ашигладаг тэмдэглэгээтэй андуурахааргүй байна;
- (4) тухайн саадын учруулж болох аюулыг нэмэгдүүлэхгүй байхаар тэмдэглэгээ хийнэ.

В.6. Дарцаг ашиглах

- (a) Саадыг тэмдэглэхэд ашиглаж байгаа дарцаг нь:
- (1) тухайн байгууламжийн эргэн тойронд, дээр нь, эсхүл хамгийн өндөр цэгийг тойруулж байрлуулна;
 - (2) тухайн саадын учруулж болох аюулыг нэмэгдүүлэхгүй байхаар байна.
- (b) Том хэмжээтэй саад, эсхүл өөр хоорондоо ойр байрласан бүлэг саадыг тэмдэглэхэд дарцгийг ашиглаж байгаа бол, 15м-ээс ихгүй зай тутамд байрлуулна.
- (c) Суурин саадыг тэмдэглэхэд ашиглаж байгаа дарцаг нь:
- (1) 600 х 600мм-ээс багагүй хэмжээтэй;
 - (2) улбар шар өнгөтэй, эсхүл хоёр гурвалжин хэсгээс бүрдэх ба нэг нь улбар шар, нөгөө нь цагаан өнгөтэй, эсхүл нэг нь улаан, нөгөө нь цагаан өнгөний хослолтой байх ба эдгээр өнгө нь орчны суурь өнгөтэй уусаж байгаа бол, өөр тод харагдахуйц өнгө ашиглаж болно.
- (d) Хөдөлгөөнтэй саадыг тэмдэглэхэд ашиглаж байгаа дарцаг нь:
- (1) 900 х 900мм -ээс багагүй хэмжээтэй;
 - (2) дөрвөлжин хээтэй байна:
 - (i) тэгш өнцөгтийн талууд нь 300мм-ээс багагүй;
 - (ii) тэгш өнцөгт бүр нь өөр хоорондоо ялгагдах эрс тэс, тод өнгөтэй ба суурь өнгөнөөсөө ялгарч харагдахаар байна;
 - (iii) тухайн орчны суурь өнгөнд уусахаас бусад тохиолдолд, улбар шар ба цагаан, эсхүл улаан болон цагаан өнгөөр хослуулан.

В.7. Саадын гэрэл ашиглах

- (a) Саадыг гэрэлтүүлэх шаардлагатай бол, бага, дунд, эсхүл өндөр чадалтай, эсхүл эдгээр гэрлийг хослуульж болно.
- (b) Гэрлийн чадал нь тухайн саадын аюул учруулах овор хэмжээг нэмэгдүүлэхээргүй байна.
- (c) Бага чадалтай саадын гэрэлтүүлгийн хэмжээ нь хангалтгүй, эсхүл холоос танигдах тусгай анхааруулга шаарддаг бол, дунд, эсхүл өндөр чадалтай саадын гэрэлтүүлгийг ашиглана.
- (d) Том овор хэмжээтэй, эсхүл 45м-ээс өндөр саадыг тэмдэглэхдээ дунд чадалтай гэрлийг дангаар нь, эсхүл бага чадлын гэрэлтэй хослуулан ашиглана.
- (e) Өндөр чадалтай саадын гэрэлтүүлэг нь өдөр шөнийн аль ч үед ашиглах зориулалттай байна.
- (f) Өндөр чадалтай саадын гэрэлтүүлгийг өндөр саадыг илэрхийлэхэд хэрэглэнэ, хэрэв саадын өндөр 150м-ээс илүү бол.

В.8. Саадын гэрэлтүүлгийн байрлал

(a) Саадын гэрэлтүүлэг шаардлагатай бол, тухайн саадын оройн цэг дээр нэгээс доошгүй гэрэл байрлуулах ба хэрэв яндангийн төрлийн хийц бол, бохирдлыг багасгахаар гэрлийг оройн цэгээс доор байрлуулна.

(b) Саадын орой нь орчин тойрны газрын гадаргуугийн түвшнээс 45м-ээс өндөр бол, гэрлийг саадын дундах түвшинд дараах байдлаар байрлуулна:

- (1) оройн гэрэл болон газрын түвшний хооронд аль болох тэнцүү зайд байхаар;
- (2) хэрэв бага, эсхүл дунд чадалтай гэрэлтүүлэг ашиглах бол, хоорондоо 45м-ээс холгүй зайд байхаар.

(c) Өндөр чадалтай гэрэлтүүлэг саадын дээр ашиглах бол, гэрэл нь хоорондоо 105м-ээс холгүй зайтай байна.

(d) Тэмдэглэгдсэн байх түвшин бүрийн гэрлийн тоо болон байрлал нь тухайн саадын азимутын өнцөг бүрийг тэмдэглэсэн байхаар байна.


(e) Саадын дээр байрлах гэрэл аливаа чиглэлд өөр байгууламжаар халхлагдаж байгаа бол, нэмэлт, эсхүл орлох гэрлийг саадын дээр, тухайн саадын ерөнхий байдлыг харагдахаар байрлуулна.

(f) Оройн гэрлийг дараах байдлаар байрлуулна:


- (1) тухайн саадыг хязгаарлах гадаргуугаас илүү гарсан саадын үзүүр, эсхүл булан бүр харагдахаар;
- (2) далайн түвшнээр хамгийн өндөр илүү гарсан саадын үзүүр, эсхүл булан бүр харагдахаар;
- (3) яндан төрлийн байгууламж бол, түүний оройгоос доош 1500мм-ээс 3000мм-ийн хооронд (Зураг В.2 ба В.3);
- (4) босоо цамхаг, эсхүл антен бол, оройдоо өндөр чадалтай саадын гэрэлтэй байх ба, гэхдээ энэ нь боломжгүй бол, хамгийн өндөр боломжтой цэгт түүнийг байрлуулах бөгөөд цагаан өнгийн дунд чадалтай гэрлийг оройн цэгт бэхэлнэ.

(g) Том хэмжээтэй саад, эсхүл өөр хоорондоо ойр байрласан бүлэг саадыг:

- (1) тухайн саадын ерөнхий байдал болон овор хэмжээг илэрхийлэхээр саадыг хязгаарлах гадаргуугаас хамгийн өндөр саадын үзүүр, эсхүл булан бүрийн оройн гэрэл харагдах хэлбэрээр байрлуулна;
- (2) хэрэв хоёр, эсхүл түүнээс олон булангууд нь ижил өндөртэй бол, буултын бүсэд хамгийн ойр байрлах буланд гэрлийг байрлуулна;
- (3) бага чадалтай гэрэл шаардлагатай бол, хоорондоо 45м-ээс холгүй зайтай байна;
- (4) өндөр чадалтай гэрэл шаардлагатай бол, хоорондоо 90м-ээс холгүй зайтай байна.



Зураг В.2 - өндөр байгууламж дахь гэрэлтүүлэг, тэмдэглэгээ байрлуулах жишээ



Зураг В.3 - Байгууламжийн гэрэлтүүлэг

В.9. Бага чадалтай саадын гэрлийн үзүүлэлт

(a) Суурин саадын бага чадалтай гэрэл нь дараах үзүүлэлттэй тогтмол улаан гэрэлтэй байна:

- (1) байрлуулсан газрынхаа эргэн тойрноос тод харагдахуйц;
- (2) улаан гэрлийн 10 канделаас багагүй.

(b) Хөдөлгөөнт саадын бага чадалтай саадын гэрэл нь:

- (1) шар өнгөтэй, эсхүл хэрэв шар өнгө тохирохгүй бол, улаан өнгөтэй;
- (2) анивчих давтамж нь минутанд 60-90 удаа;
- (3) шар, эсхүл улаан гэрлийн идэвхтэй чадал нь 40 канделаас багагүй байна.

В.10. Дунд чадалтай саадын гэрлийн үзүүлэлт

Дунд чадалтай саадын гэрэл нь:

- (1) өндөр чадалтай гэрэлтүүлэгтэй хамтатган ашиглах бол, цагаан өнгөтэй байхаас бусад тохиолдолд, улаан өнгөтэй;
- (2) анивчих давтамж нь минутанд 60-90 удаа;
- (3) улаан гэрлийн идэвхтэй чадал нь 1600 канделаас багагүй байна.

В.11. Өндөр чадалтай саадын гэрлийн үзүүлэлт

Өндөр чадалтай саадын гэрэл нь:

- (1) цагаан өнгөтэй;
- (2) зэрэг анивчих давтамж нь минутанд 40-60 удаа;
- (3) татлаган тулгуурт цамхаг дээр суурилуулснаас бусад тохиолдолд, идэвхтэй чадал нь дараах суурийн гэрэлтэлтээс шалтгаалан харилцан адилгүй байна:

Суурийн гэрэлтэлт	Идэвхтэй чадал
500кд/м ² -с их	минимум 200 000кд
50- 500кд/м ²	20 000кд ± 25%
50кд/м ² -с бага	2000кд ± 25%

Хавсралт С - Халхлалт

(a) Дарга, нислэг үйлдэх агаарын зайд аюултай гэж тодорхойлсон саад нь, хэрэв халхлагдсан байна гэж үзвэл, тэмдэглэгээ, эсхүл гэрэлтүүлэгтэй байхыг шаардахгүй байж болно.

(b) Бусад байгууламжаас нам өндөртэй дараах байгууламжийг бусад байгууламжаар халхлагдсан гэж авч үзэж болно:

- (1) нислэг үйлдэх агаарын зайд аюултай гэж тогтоогдсон;
- (2) саадын стандарт тэмдэглэгээ, эсхүл гэрэлтүүлгээр тэмдэглэгдсэн.


(c) Саадыг хязгаарлах гадаргууг огтолсон байгууламж нь халхлагдсан эсэхийг тодорхойлохын тулд нисэхийн судалгаа шаардлагатай байж болно. ,

(d) Халхалсан байгууламж нь байнгын байна.


(e) Энэ зүйлийн (c)-гийн зорилгоор, хэрэв нислэгийн үйл ажиллагааны хэлбэр, төрөл, нягтрал хэрхэн өөрчлөгдөхөөс үл хамааран, боломжит хамгийн урт хэтийн төлөвлөгөөнд, түүнийг буулгах бодит бололцоо, боломж байхгүй, эсхүл үндэслэлгүй бол, тухайн байгууламжийг байнгын гэж ангилна.

(f) Тухайн саад нь ойртолтын, эсхүл хөөрөлтийн гадаргууд, эсхүл шилжилтийн хажуу, эсхүл дотоод хэвтээ гадаргууд халхлагдан байрлаж байгаа бол, Зураг С.1 болон С.2-т үзүүлсэн халхлагдсан байгууламжийн шалгуурыг хангасан байна.

(g) Энэ зүйлийн (e)-д заасан бүсийн гадна байгаа саад нь, хэрэв халхалсан байгууламжаас 600м-ээс дотогш байрлаж байгаа бол, түүнийг халхлагдсан гэж үзэж болно.



Зураг С.1 - Ойртолт болон хөөрөх гадаргууг халхлах



Зураг С.2. - Шилжилтийн болон хэвтээ гадаргууг халхлах

--oOo--